



**ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН ЗАХИРАМЖ**

2020 оны 04 сарын 08 өдөр

Дугаар А/148

Арвайхээр

**Малын халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх
арга хэмжээг зохион байгуулах тухай**

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3.а, Мал, амьтны эрүүл мэндийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2, 9 дүгээр зүйлийн 9.4, 9.5, 9.6 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Мал сүргийг халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний ажлыг 2020 оны 04 дүгээр сарын 10-наас 10 дугаар сарын 20 хүртэл хугацаанд зохион байгуулж ажиллахыг аймгийн Мал эмнэлгийн газар, сумдын Мал эмнэлгийн тасаг, Мал эмнэлгийн үйлчилгээний аж ахуйн нэгжүүдэд үүрэг болгосугай.

2. Урьдчилан сэргийлэх арга хэмжээг хэрэгжүүлэх, хяналт тавих, товлосон хугацаанд мал сүргийг бэлэн байлгах ажлын хэсэг томилж, үүрэгжүүлж ажиллахыг сумын Засаг дарга нарт үүрэг болгосугай.

3. Халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээнд зарцуулагдах тарилгыг цаг хугацаанд нь татан авч, хувийн мал эмнэлгийн үйлчилгээний нэгжүүдэд хүргэх, мэргэжил арга зүйн туслалцаа дэмжлэг үзүүлж, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг аймгийн Засаг даргын дэргэдэх Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т даалгасугай.

4. Урьдчилан сэргийлэх арга хэмжээний явц, чанар, үр дүнтэй уялдуулан санхүүжилт олгох болон холбогдох баримт бичгийн бүрдүүлэлт, мэдээ тайланд хяналт тавьж ажиллахыг Мал эмнэлгийн газар (А.Нямдаваа)-т үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Г. ГАНБОЛД

011100319